

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: А.Нанжидмаа
Утас: 70453799, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	4
3.1 Ерөнхий зүйл	16
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал.....	17
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал.....	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫГ
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЦОЛМОН ТАНАА

2022.02.25 № УВА-2022/56/НА -СНА АТЦС
танай -ны № -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Увс аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Төсвийн хөрөнгөөр худалдан авсан Сум хөгжүүлэх сангийн зээлийн тооцооллын программ хангамж, Малын удам зүйн үнэлгээний программ хангамж 4,200.0 мянга, 2018-2020 онд хэрэгжиж дууссан Хүлэмж” дэд хөтөлбөр болон төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн 8 нэр төрлийн 95,144.2 мянга, нийт 99,344.2 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материал дансанд бүртгэсэн зэрэг зөрчил Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх” заалт, УСНББОУС 17 стандартын 13 дахь заалттай нийцэхгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх, Ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200260417

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	188,710,483.19	272,287,017.03
33	АВЛАГА	0	12,500,000.0
3352	Хувь хүмүүсээс авах авлага		12,500,000.0
34	УРЬДЧИЛГАА		7,200,000.0
34600	Урьдчилж гарсан зардал		7,200,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	188,710,483.19	252,587,017.03
351	Түүхий эд материал	23,551,261.19	88,778,795.03
35110	Тусгай зориулалттай материал	23,551,256.10	88,778,795.03
35400	Хангамжийн материал	154,874,222.00	163,808,222.00
35420	Аж ахуйн материал	154,874,222.00	156,453,222.00
35600	Мал амьтад	10,285,000.00	7,355,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	567,018,249.56	534,962,598.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	567,018,249.56	534,962,598.16
39200	Биет хөрөнгө	458,698,249.56	426,942,598.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	419,276,445.84	419,276,445.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(25,556,796.24)	(38,335,194.36)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	193,826,212.52	140,391,772.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	(150,864,212.52)	(110,670,272.52)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	111,359,839.31	84,410,750.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(97,978,848.75)	(75,223,054.03)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,312,947.71	21,595,505.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,677,338.31)	(14,503,355.05)
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,399,609.19	17,910,999.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(22,399,609.19)	(17,910,999.20)
39300	Биет бус хөрөнгө	108,320,000.00	108,020,000.00
39301	Программ хангамж	1,720,000.00	1,720,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(520,000.00)	(820,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	107,120,000.00	107,120,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	755,728,732.75	807,249,615.19
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,332,370.00	650,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,332,370.00	650,000.00
413	Өглөг	3,332,370.00	650,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,069,070.00	
4136	Бусад өглөг	1,263,300.00	650,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	293,300.00	200,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	970,000.00	450,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	752,396,362.75	806,599,615.19

51	Засгийн газрын хувь оролцоо	752,396,362.75	806,599,615.19
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	790,071,309.76	790,071,309.76
51200	Хуримтлагдсан үр дүн	(303,372,809.82)	(246,975,988.88)
51210	Өмнөх үеийн үр дүн	(274,502,409.77)	(301,179,241.32)
51220	Тайлант үеийн үр дүн	(28,870,400.05)	54,203,252.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	265,697,862.81	263,504,294.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	755,728,732.75	807,249,615.19

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	470,919,330.30	555,102,516.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,657,230.30	69,846,679.80
120	Нийтлэг татварын бус орлого	23,657,230.30	69,846,679.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	23,657,230.30	69,846,679.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,286,000.00	6,355,465.00
120045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,371,230.30	63,491,214.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	447,262,100.00	485,255,836.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	444,332,100.00	394,447,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	444,332,100.00	394,447,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,930,000.00	90,808,536.42
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,930,000.00	77,360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	808,536.42
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	12,640,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	499,789,730.35	500,710,934.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	499,789,730.35	500,710,934.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,309,840.35	443,756,919.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,004,053.00	220,827,754.67
210101	Үндсэн цалин	159,508,132.00	169,322,805.40
210102	Нэмэгдэл	52,725,725.00	46,412,573.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,770,196.00	5,092,376.07
210104	Урамшуулал		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,329,370.00	28,558,326.00
210201	Тэтгэврийн даатгал	18,485,870.00	19,567,916.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,210,900.00	2,247,502.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,768,700.00	1,798,081.98
210204	Ажилгүйдлийн даатгал	442,200.00	449,620.50
210205	Эрүүл мэндийн даатгал	4,421,700.00	4,495,204.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,752,968.00	34,570,541.00

210301	Гэрэл, цахилгаан	3,495,974.00	4,430,647.00
210302	Түлш, халаалт	19,459,220.00	28,304,320.00
210303	Цэвэр, бохир ус	1,797,774.00	1,835,574.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	13,361,209.00	20,134,406.00
210401	Бичиг хэрэг	1,675,609.00	2,090,490.00
210402	Тээвэр, шатахуун	8,240,300.00	14,095,532.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,398,200.00	2,435,584.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	534,000.00	455,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,513,100.00	1,057,800.00
2105	Нормативт зардал	813,800.00	5.09
210501	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	5.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	313,800.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,475,100.00	815,700.00
210601	Урсгал засвар	7,475,100.00	815,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,894,600.00	3,128,000.00
210702	Дотоод албан томилолт	1,894,600.00	3,128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,149,480.00	82,336,684.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,146,500.00	77,538,496.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	224,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	643,500.00	178,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	367,500.00	281,408.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	1,357,400.00	3,928,000.00
210807	Газрын төлбөр	355,580.00	355,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,529,260.35	53,385,502.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,650,530.30	19,928,179.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,590,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,878,730.05	31,867,322.38
2131	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,479,890.00	56,954,015.75
2132	Засгийн газрын дотоод шилжүүлэг		

213204	Бусад урсгал шилжүүлэг	18,767,894.00	2,402,000.00
213208	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,897,894.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,870,000.00	2,402,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,711,996.00	54,552,015.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,711,996.00	54,552,015.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(28,870,400.05)	54,391,581.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV)-(V)		188,329.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		188,329.02
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-	(188,329.02)
	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(28,870,400.05)	54,203,252.44

2.3. АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	790,071,309.76	265,697,862.81	-274,502,409.77	781,266,762.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	790,071,309.76	265,697,862.81	-274,502,409.77	781,266,762.80
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт				0.00
8	Зарласан ногдол ашиг				0
9	Тайлант үеийн үр дүн			-28,870,400.05	-28,870,400.05
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	790,071,309.76	25,697,862.81	-303,372,809.82	752,396,362.75
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	790,071,309.76	265,697,862.81	-303,372,809.82	752,396,362.75
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			2,193,568.50	2,193,568.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-2,193,568.50		-2,193,568.50
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	
19	Тайлант үеийн үр дүн			54,203,252.44	54,203,252.44
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	790,071,309.76	263,504,294.31	-246,975,988.88	806,599,615.19

2.4 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	470,315,939.00	476,906,301.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,626,000.00	4,150,465.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,626,000.00	4,150,465.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,626,000.00	4,150,465.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,626,000.00	4,150,465.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	468,689,939.00	472,755,836.42
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	460,332,100.00	394,447,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	460,332,100.00	394,447,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,357,839.00	78,308,536.42
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,930,000.00	77,360,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,427,839.00	808,536.42
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	140,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	468,885,939.00	476,906,301.42
21	УРСГАЛ ЗАРДАЛ	468,885,939.00	476,906,301.42
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	428,376,049.00	419,432,285.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	217,004,053.00	220,827,754.67
210101	Үндсэн цалин	159,508,132.00	169,322,805.40
210102	Нэмэгдэл	52,725,725.00	46,412,573.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,770,196.00	5,092,376.07
210104	Урамшуулал		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,329,370.00	28,558,326.00
210201	Тэтгэврийн даатгал	18,485,870.00	19,567,916.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,210,900.00	2,247,502.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,768,700.00	1,798,081.98
210204	Ажилгүйдлийн даатгал	442,200.00	449,620.50
210205	Эрүүл мэндийн даатгал	4,421,700.00	4,495,204.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,752,968.00	34,570,541.00
210301	Гэрэл, цахилгаан	3,495,974.00	4,430,647.00
210302	Түлш, халаалт	19,459,220.00	28,304,320.00

Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210303	Цэвэр, бохир ус	1,797,774.00	1,835,574.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	11,225,339.00	22,440,276.00
210401	Бичиг хэрэг	1,455,109.00	2,184,290.00
210402	Тээвэр, шатахуун	6,538,230.00	15,797,602.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,398,200.00	2,435,584.00
210404	Ном хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал	534,000.00	455,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,299,800.00	1,567,800.00
2105	Нормативт зардал	813,800.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,000.00	
210502	Хоол, хүнс		
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	313,800.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,328,600.00	1,133,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	7,328,600.00	1,133,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,894,600.00	3,128,000.00
210702	Дотоод албан томилолт	1,894,600.00	3,128,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,577,319.00	105,684,188.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	134,574,339.00	93,686,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	224,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	643,500.00	178,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	367,500.00	281,408.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,357,400.00	11,128,000.00
210807	Газрын төлбөр	355,580.00	355,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	3,090,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	450,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,590,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,509,890.00	57,474,015.75
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		

2132	Бусад урсгал шилжүүлэг	17,797,894.00	2,922,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,897,894.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,900,000.00	2,922,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	22,711,996.00	54,552,015.75
	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,711,996.00	54,552,015.75
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,430,000.00	
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,430,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,430,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	1,430,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,430,000.00	
	ХӨРӨНГӨ		
	ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	1,430,000.00	
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	469,607,300.00	345,278,285.67	124,329,014.33	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	469,607,300.00	345,278,285.67	124,329,014.33	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	465,414,500.00	342,356,285.67	123,058,214.33	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,090,700.00	220,827,754.67	262,945.33	
210101	Үндсэн цалин	170,123,000.00	169,322,805.40	800,194.60	
210102	Нэмэгдэл	45,273,200.00	46,412,573.20	(1,139,373.20)	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,694,500.00	5,092,376.07	602,123.93	
210104	Урамшуулал				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,847,200.00	28,558,326.00	1,288,874.00	
210201	Тэтгэврийн даатгал	21,003,600.00	19,567,916.08	1,435,683.92	
210202	Тэтгэмжийн даатгал	2,210,900.00	2,247,502.48	(36,602.48)	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,768,700.00	1,798,081.98	(29,381.98)	
210204	Ажилгүйдлийн даатгал	442,200.00	449,620.50	(7,420.50)	
210205	Эрүүл мэндийн даатгал	4,421,800.00	4,495,204.96	(73,404.96)	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,013,400.00	34,570,541.00	1,442,859.00	
210301	Гэрэл, цахилгаан	5,210,100.00	4,430,647.00	779,453.00	
210302	Түлш, халаалт	27,973,500.00	28,304,320.00	(330,820.00)	
210303	Цэвэр, бохир ус	2,829,800.00	1,835,574.00	994,226.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	22,453,800.00	22,440,276.00	13,524.00	
210401	Бичиг хэрэг	2,184,300.00	2,184,290.00	10.00	
210402	Тээвэр, шатахуун	15,797,900.00	15,797,602.00	298.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,447,800.00	2,435,584.00	12,216.00	
210404	Ном хэвлэл				
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	455,100.00	455,000.00	100.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,568,700.00	1,567,800.00	900.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,133,200.00	1,133,200.00	0,0	
210601	Багаж, техник, хэрэгсэл				
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл				

210604	Урсгал засвар	1,133,200.00	1,133,200.00	
2107	Томилолт, зочны зардал	3,440,000.00	1,768,000.00	1,672,000.00
210702	Дотоод албан томилолт	3,440,000.00	1,768,000.00	1,672,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,246,200.00	31,408,188.00	116,838,012.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	135,547,200.00	19,410,000.00	116,137,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох			
210803	Даатгалын үйлчилгээ	178,200.00	178,200.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	832,900.00	281,408.00	551,492.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,177,900.00	11,128,000.00	49,900.00
210807	Газрын төлбөр	455,000.00	355,580.00	99,420.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,190,000.00	1,650,000.00	1,540,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,600,000.00	1,500,000.00	100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,590,000.00	150,000.00	1,440,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,192,800.00	2,922,000.00	1,270,800.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	4,192,800.00	2,922,000.00	1,270,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг			
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,270,000.00		1,270,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,922,800.00	2,922,000.00	800.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	315,573,600.00	345,278,285.67	(29,704,685.67)
	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	315,573,600.00	345,278,285.67	(29,704,685.67)
	Улсын төсвөөс санхүүжих	315,573,600.00	345,278,285.67	(29,704,685.67)
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС			
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		77,076,000.00		
21	УРСГАЛ ЗАРДАЛ		77,076,000.00		
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		77,076,000.00		
2104	Хангамж, бараа материалын зардал				
210401	Бичиг хэрэг				
210402	Тээвэр, шатахуун				
2107	Томилолт, зочны зардал		1,360,000.00		
210702	Дотоод албан томилолт		1,360,000.00		
210604	Урсгал засвар				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		74,276,000.00		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		74,276,000.00		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,440,000.00		
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,440,000.00		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ				
2132	Бусад урсгал шилжүүлэг				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал				
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		77,360,000.00		
31	Нэмэлт санхүүжилтийн орлого				
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		77,360,000.00		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь хүнс, хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр гарсан хууль, тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, хүн амыг эрүүл хүнсээр хангах, баталгаат байдлыг дээшлүүлснээр нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, малын чанар үүлдэр угсаа ашиг шимийг сайжруулан эрчимжсэн аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар салбарын эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4,997.8 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 500,710.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 5,007.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 4,005.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,020.9 мянган төгрөгөөр буюу хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0	12,500.0	12,500.0
Бараа материал	188,710.5	252,587.0	63,876.5
Үндсэн хөрөнгө	567,018.2	534,962.6	-32,055.5
Нийт хөрөнгө	755,728.7	794,749.6	39,020.9
Өр төлбөр	3,332.3	650.0	-2,682.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	752,396.3	794,099.6	41,703.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	755,728.7	794,749.6	39,020.9

Авлага дансны үлдэгдэл 12,500.0 мянга болж нэмэгдсэн акталсан үндсэн хөрөнгө борлуулсны орлоготой холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 252,587.0 мянган төгрөг болж 63,876.5 мянган төгрөгөөр өссөн тайлант оны бэлчээрийн ургамал хамгааллын ажлын 51,513.0 мянган төгрөгийн бодис хугацаа хоцорч ирсэн тул тусгай зориулалттай материалд орлогоор хүлээн зөвшөөрсөн бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 534,962.0 мянган төгрөг болж 32.055.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2021 оны 29 дүгээр тогтоолын үндэслэн элэгдлээ бүрэн нөхөж, ашиглалтгүй болсон 87 төрлийн 99,589.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 806,599.6 мянган төгрөг болж 54,203.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 555,102.5 мянган төгрөгөөр буюу 17.8 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 921.2 мянган төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан тээвэр, шатахуун, түлш халаалтын зардлууд байна. Энэ нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 672,392.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 672,392.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 358,043.0 мянган төгрөгөөр бууруулж 314,349.6 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан баталдагтай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 314,349.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 315,573.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 398,597.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 345,278.2 мянган төгрөгийг зарцуулж 53,319.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 345,278.2 мянган төгрөг буюу 86.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 77,360.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 808.5 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 140.0 мянга, нийт 78,308.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс дотоод томилолтын зардалд 1,360.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 74,276.0 мянга, хичээл үйлдвэрлэл зардалд

1,440.0 нийт 77,076.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,232.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 106 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, хугацаа хоцроож 45 мэдээлэл байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаал “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12-т “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын тооцоог гаргаж тайланг тушаана” гэж заасан байхад 2021 оны 12 дугаар сарын 17, 21, 28-ны өдрүүдэд орсон орлогыг байгууллагын дансанд тушаагаагүй байна.

2. Төрийн өмчийн бодлогын зохицуулалт газрын 2021 оны 29 дүгээр тогтоол шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж ажиллах.
3. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр “Шинэ хөдөө-Увс” төслийн хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжиж санхүүжигдсэн 9,800.0 мянган төгрөгийн улаан сармисны үрийг нутагшуулах ажлын гүйцэтгэлийг Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны хөрөнгийн зарцуулалт үр дүн нийцлийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 111,844.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 12,500.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 99,344.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. дэх заалт “Үнэн зөв байх”, 14 дүгээр зүйл 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2. дахь заалт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг тус тус зөрчин хөрөнгө худалдан борлуулсны орлого 12,500.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байсныг авлагаар тусгаж залруулав.

4.4 Зөвлөмж

1.1 Илрүүлэлт: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан Сум хөгжүүлэх сангийн зээлийн тооцооллын программ хангамж, Малын удам зүйн үнэлгээний программ хангамж 4,200.0 мянга, 2018-2020 онд хэрэгжиж дууссан “Хүлэмж” дэд хөтөлбөр болон төсвийн хөрөнгөөр худалдан бэлтгэсэн 8 нэр төрлийн 95,144.2 мянга, нийт 99,344.2 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн.

- 1.1. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4,200.0 мянган төгрөгийн үнэ бүхий программ хангамжийг үндсэн хөрөнгийн дансанд, 8 нэр төрлийн 95,144.2 мянган төгрөгийн хөрөнгийн эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн үнэн зөв бүртгэх.

Аудитаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян. төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хүнс, хөдөө аж ахуйн газар	2	111,844.2	1	12,500.0					1	99,344.2

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

/А.НАНЖИДМАА/

2022 оны 02 сарын 25-ны өдөр